

Их Эзэндээ ханд

Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн

Ахлагч Дональд Л.Холстром

Дэлхийн нөхцөл байдал өөрийг тань сүнслэг байдлын хувьд хэзээ ч бүү эрэмдэг зэрэмдэг болгог.

Олон жилийн өмнө би элэг эмтрэм эмгэнэлт явдлын гэрч болсон юм. Нэгэн залуу хос анхныхаа үрийн зулай үнэрлэх гээд тэсч ядан амьдралынхаа гайхамшигтай мөчийг хүлээн горьдлого, сэтгэл догдлолоор дүүрэн байлаа. Хүүхэд төрүүлэх үед хүндрэл тохиолдож, бяцхан үр нь эндэв. Уй гашуу нь гаслан болж, гаслан нь уур хилэн болоод, уур хилэн нь эмчид ял тулгах санаагаар солигдон, бүх хариуцлагыг хүлээсэн эмчид өс хонзон санахад хүргэжээ. Залуу хосын эцэг эх, хамаатан садан нь бүгд эмчийг ажлаас нь халуулж, нэр төрийг нь гутаахыг санаархаж байсан гэнэ. Гэр бүл уур хилэнгээр дүүрэн өдөр хоног, саруудыг өнгөрөөсөөр сүүлдээ тэд бүр Их Эзэнд хүртэл гомдох болов. “Ийм аймшигтай зүйл болохыг Тэр яагаад зөвшөөрөв өө?” Сүмийн удирдагчид болон гишүүд олон дахин тэдэнд сүнслэг болон сэтгэл санааны тайвшралыг олохыг санал болгон туслахыг хичээсэн ч, тэд тэр бүгдийг үгүйсгэж, өөрсдийгөө Сүмээс холдуулжээ. Энэ байдал тэдний удмын дөрвөн үед нөлөөлөн нэгэн цагт байсан Их Эзэн болон Түүний Сүмд итгэх итгэл, сүсэг бишрэл, гэр бүлийнхний сүнслэг байдал хэдэн арван жилээр үгүй болсон байна.

Амьдралын хамгийн хүнд хэцүү нөхцөлд ч амар амгалангийн нэгэн эх сурвалж үргэлж байдаг. Энхийн Жонон, Есүс Христ, “Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарт амралтыг өгье.” (Матай 11:28) гэсэн урилгын хамт ач ивээлээ илгээсэн билээ. Тэр мөн “... Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна” (Иохан 14:27) гэж амласан юм.

Эмээ өвөө хоёр маань хүү (миний аав), охин хоёртой байсан юм. Аав маань Хавайд номлол хийж, цэргийн алба хаасны дараа 1946 онд тогтвортой ажил олж, гэр бүлээ тэтгэхээр эцэг эх болон эгчийнхээ амьдарч байсан Солт Лейк хотод очсон юм. Аавын маань эгч 1946 онд гэрлэж, дөрвөн жилийн дараа жирэмсэлжээ. Охин нь (энэ тохиолдолд цорын ганц охин нь) анхны хүүхдээ төрүүлэхийг эцэг эхчүүд нь сэтгэл догдлон тэсч ядан хүлээдэг. Түүнийг ихэр хүүхэд тээж буй гэдгийг хэн ч мэдээгүй гэнэ. Харамсалтай нь төрөлтийн хүндрэлээс эх нь нас барж, ихрүүд эндсэн ажээ.

Эмээ өвөө маань уй гашууд автсан ч уй гашуу нь удалгүй тэднийг Их Эзэн болон Түүний Цагаатгалд хандахад хүргэсэн гэдэг. Тэд яагаад ийм зүйл тохиолдсон мөн хэн буруутан бэ гэдгийг эрж хайлгүй, зөв шударга амьдрахад хамаг анхаарлаа төвлөрүүлсэн юм. Эмээ өвөө маань хэзээ ч хөрөнгө мөнгөтэй, баян чинээлэг, нийгэмд нэрд гарсан нэр хүндтэй хүмүүс байгаагүй. Тэд хэзээ ч Сүмийн өндөр албан тушаал хашиж яваагүй, сүсэг бишрэлтэй, энгийн Хожмын Үеийн Гэгээнтнүүд байсан юм.

Тэд 1956 онд тэтгэвэртээ гарсны дараа үр ач нартайгаа байхаар Хавай уруу нүүсэн юм. Өнгөрсөн он жилүүдийн бүхий л хугацааг гэр бүлээ хайрлах, Сүмдээ үйлчлэх болон хамтдаа байхад зориулсан аж. Тэдний хувьд зүгээр л хамт байх нь хамгийн их баяр баясгалан байсан юм. Эмээ өвөө хоёр маань бие биенээсээ хол байх дургүй байсан ба тэр бүү хэл хэн нэг нь түрүүлж нас барах юм бол амьд үлдсэн нэгнийхээ сүнсний дэлхийд түргэн ирэх замыг нь бэлтгэх тухай хүртэл ярьдаг байсан юм. 90 насныхаа ойг тэмдэглэхийн өмнө, гэрлээд 65 жил хамт амьдарсны дараа тэд хоорондоо хэдхэн цагийн зайтай ертөнцийн жамаар өөд болцгоосон юм. Бишопынх нь хувьд би тэдний оршуулгын үйл ажиллагааг удирдсан юм.

Арт өвөө, Лоу эмээ нарын итгэлтэй байдал ялангуяа хүндрэл бэрхшээлтэй тулгарах үед гаргасан тэдний итгэл одоо дөрвөн үеийг дамжин нөлөөлсөөр байна. Миний хамгийн бага охин дүү төрөлтийн хүндрэлээс нас барахад аав, ээжид маань эцэг эхийнх нь итгэл шууд, гүн гүнзгийгээр нөлөөлсөн юм. Дүү маань 34 настайдаа төрөөд, арав хоносны дараа 10 хоногтойгоос 8 настай 4 хүүхдээ орхин одсон юм. Өмнөх үе удмаасаа олсон итгэлийн үлгэр жишээгээр аав ээж маань ямар ч эргэлзээгүйгээр Их Эзэний тайвшралыг эрэн Түүнд хандсан юм.

Дэлхийн өнцөг булан бүрд тэр дундаа Сүмийн гишүүдийн дунд агуу баяр баясгалан, агуу зовлон аль аль нь л байгаа. Хоёул төлөвлөгөөний нэг хэсэг. Аль нэг нь үгүй бол бид нөгөөдөхийг нь мэдэж чадахгүй. “Тэд баясгалантай байж болохын тул хүмүүн байх бөлгөө” (2 Нифай 2:25), “Учир юун хэмээвээс бүх зүйлд сөрөг тал байх нь зайлшгүй” (2 Нифай 2:11) гэсэн судрын хэсгүүд нь бие биенээ үгүйсгэсэн бус харин тэд бие биенээ нөхөх уялдаа холбоотой юм. Залуу Алма Их Эзэнд хандах үед юу мэдэрсэнээ тайлбарлахдаа “бодгаль минь ямархуу шаналалд байсан лугаа адил тийм үлэмжийн баяслаар дүүргэгдсэн байв” (Алма 36:20) гэсэн байдаг.

Зарим хүмүүс хүнд асуудлуудыг даван туулж чаддаг байхад зарим нь жижиг зүйлийг том асуудал болгон хувиргадаг. Саймондс Райдер Иосеф Смиттэй уулзаж Сүмийн тухай сонсох хүртэл Кампбеллын дагалдагчид шашны байгууллагын удирдагч байсан юм. Тэрхүү уулзалтын сүнслэг байдлын нөлөөгөөр тэр 1831 оны

зургадугаар сард сүмийн гишүүн болжээ. Тэр удалгүй ахлагч болон номлолын ажилд дуудагдсан боловч Тэргүүн Зөвлөлөөс явуулсан түүний дуудлагын захидал болон сургаалыг номлох эрхийн бичигт овгийн нэг үгийг нь буруу бичсэнээс болж, дуудлагадаа болон дуудсан хүмүүст эргэлзэж эхлэв. Тэр номлолд явахгүйгээр шийдэж, Сүмийг үгүйсгэн, удалгүй бүр Иосеф болон Сүмийн эсрэг өс хонзон санаж, үзэн ядалтанд хөтлөгдсөн аж. Нэгэн хилэнцэт танхайрагч 1832 оны гуравдугаар сард Иосеф Смит, Сидней Ригдон нарыг гэрээс нь хүчээр гаргаж, шөнийн турш тэдэнд давирхай түрхэн өд наах үедээ “Саймондс, хүүе Саймондс давирхайтай хувин хаана байна?” (*History of the Church*, 1:262--263) гэж хашгирч байхыг нь сонсчээ. Арван сар ч хүрэлгүй хугацаанд Саймондс Райдер сүнслэг хөрвөгчөөс танхайрагчдын удирдагч болсон юм. Түүний сүнслэг байдлын доройтол нь захиан дээр овгийн нэг үсгийг нь буруу бичсэнд гомдсоноос үүдэлтэй юм. Үүсвэр нь ямар хэмжээтэй байх нь хамаагүй бид асуудалд нь хэрхэн хандахаас бидний амьдралын замнал шалтгаалах болно.

Бошиглогч Иосеф Смит хувийн зовлон, аливаа сөрөг үйлдлийг хэрхэн зохицуулах тухай загварыг өгсөн байдаг. Энэхүү бурханлиг удирдамж түүнд Либертийн шоронд байхад нь илчлэгдсэн юм (Иосефын тэр үе хүртэлх амьдралыг тайлбарласан мөн ирээдүйд анхаарах зүйлсийн талаар өгүүлсэн хэсэг): Хэрэв “мунхгууд чамайг элэг доог болгон, хэрэв чи гай зовлон дундуур туулахаар дуудагдсан аваас; . . . . . хэрэв дайснууд чинь чам дээр унах аваас... хэрэв чи нүхэнд эсвээс алуурчдын гарт чам дээр тохиох үхлийн яланд хаягдах ёстой аваас... мөн элементүүд замыг хүрээлэн хаахаар нэгдэх аваас; мөн бүхний дээгүүр, хэрэв тамын эрүү чиний араас амаа томоор ангайлгах аваас, эдгээр бүх зүйл чамд туршлага суулгах болно, мөн чиний сайн сайхны төлөө байх болно гэдгийг чи мэдэгтүн, хүү минь” (С ба Г 122:1, 5-7) гэсэн байдаг. Дараа нь: “Хүний Хүү тэд бүгдээс доогуурт доош бууж ирсэн юм. Чи түүнээс илүү агуу гэж үү?” (8-р шүлэг) гэсэн мэргэн үгсийг хэлээд цааш нь маш тодорхой удирдамж, агуу амлалтыг өгсөн юм. “Тиймийн тул, зам дээрээ зогсогтун, хүний хийж чадах юмнаас бүү эмээ, учир нь Бурхан чамтай үүрд мөн мөнхөд хамт байх болно” (9-р шүлэг).

Иосеф Смит аюул бэрхшээлээр дүүрэн амьдралынхаа төгсгөл хүртэл зөв шударгаар амьдарсан. Тэрээр итгэлээр дүүрэн ирээдүйг “Миний туулахаар дуудагдсан зовлон зүдгүүрүүдийн хувьд тэдгээр нь өчүүхэн зүйл мэт санагдана, . . . . Гүнзгий ус бол дотор нь миний сэлж дассан зүйл...гай зовлондоо бахархмаар санагдана, Бурхан тэдгээр бүгдээс намайг чөлөөлсөн бөлгөө, мөн намайг энэ цагаас хойш чөлөөлөх болно” (С ба Г 127:2) хэмээн хэлсэн байдаг. Иосеф Их Эзэндээ үргэлж ханддаг байсан учраас байнга тохиох сөрөг байдлыг даван туулах итгэлтэй байсан билээ.

Хэрэв та нарт хэн нэгэн (гэр бүлийн гишүүн, найз, сүмийн гишүүн, сүмийн удирдагч, хамт ажиллагч); эсвэл ямар нэгэн зүйл (хайртай хэн нэгнээ алдах, эрүүл мэндийн асуудлууд, санхүүгийн хүндрэл, хүчирхийлэл, донтолт) гай зовлон авчирсан мэт санагдвал, асуудлыг дор нь шууд өөрт байгаа хамаг хүч тэнхээгээрээ шийд. “Зам дээрээ зогсогтун” (С ба Г 122:9); бууж өгч болохгүй. Цаг алдалгүй Их Эзэндээ ханд. Түүнд итгэх итгэлээ хөгжүүл. Түүнийг ачаанаас чинь үүрэлцэхийг, ач ивээл нь ачааг чинь хөнгөлөхийг Түүнд зөвшөөр. Биднийг “өлсгөлгүйгээр бас цангаалгүйгээр Христийн баясалд автагдахыг” (Алма 31:38) Бурхан бидэнд амласан билээ. Дэлхийн нөхцөл байдал өөрийг тань сүнслэг байдлын хувьд хэзээ ч бүү эрэмдэг зэрэмдэг болгог.

Есүс Цагаатгал хийхийн тулд “бүх зүйлээс доогуур бууж ирэн” (С ба Г 88:6) “бүх хүмүүний шаналлыг” (2 Нифай 9:21) тэвчих шаардлагатай байсан нь Түүний хамгийн агуу үлгэр жишээ болсон юм. Тиймээс Цагаатгал нь зөвхөн нүглийг даван туулахаас илүү өргөн утгатайг бид энэ жишээнээс ойлгодог. Бүх дэлхийн хамгийн агуу энэ амжилт нь “хэрэв та нар зүрх сэтгэлийн дүүрэн зорилготойгоор Их Эзэнд хандвал, мөн найдвараа Түүнд өгвөл, мөн . . . бүх чармайлтаар Түүнд үйлчилвэл тэрээр. . . та нарыг боолчлолоос гарган чөлөөлөх болно” (Мозая 7:33) гэсэн амлалтыг гүйцэлдүүлэх хүчийг Аврагчид өгсөн юм.

Бид Христийн амилалтын баярыг тэмдэглэж буй энэ өглөө бүгдээрээ “Гэрэлт үүрийн цолмон” (Илчлэлт 22:16) Их Эзэндээ хандацгаая. Тэр бидний *зам*, *үнэн* мөн *амьдралыг* (Иохан 14:6) үргэлж гэрэлтүүлэх болно гэдгийг би Есүс Христийн нэр дээр гэрчилж байна, амен.